



## Европын холбооны Бидний интернет төсөл хэрэгжинэ

© 2019-02-11

[Tweet](#) [Like 57](#) [Share](#)

Европын холбооны судалгаа, инновацийн Horizon 2020 FET (Future Emerging Technologies) хөтөлбөрийн хүрээнд 2019-2022 онд хэрэгжих WeNet – Internet of US төсөлд МУИС-ийн Хэрэглэний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн Машин оюуны лабораторийн судлаачид оролцож байна.

Энэ төсөл нь хүмүүсийн ялгамжит (diversity-aware) харилцааг хиймэл оюун, машины оролцоотойгоор сайжруулах платформ, протоколыг хөгжүүлэх зорилготой. Тодруулбал, өнөөгийн нийгмийн харилцаанд хүмүүсийн хооронд тулгарч буй асуудал, хоорондын үйл хэргийг технологийн тусламжтайгаар сайжруулах, нэг нэгэндээ тусалж чадах хүмүүсийг зөв цагт холбож өгөх ялгамжит загвар боловсруулж хэрэгжүүлэх юм. Жишээлбэл, оюутнууд хамтарч суралцах, өдөр тутмын амьдралдаа бие биедээ туслах зэрэг харилцаанд машин оролцож дэмжих болно. Үүний тулд хүмүүсийн мэдлэг туршлага, боломж бололцоо, зан төлөвийг машинд загварчилж нийгмийн-мэдлэгийн төв (social hub) үүсгэж ажиллах бөгөөд их өгөгдлийн тооцооллын аргаар мэдлэгийг боловсруулж хэрэгжүүлэх юм байна. Төслийг хэрэгжилтэд мэдлэгийн граф, хиймэл оюун, машин сургалт, ялгамжит нийгмийн харилцаа, өгөгдлийн нууцлал ба ёс суртахуун зэрэг технологи, асуудлуудыг судалж хэрэглэнд түүчээлж нэвтрүүлэхээр төлөвлөжээ.



Энэ төсөлд Итали, Кипр, Израйль, Швейцар, Испани, Их Британи, Герман, Дани, Парагвай, Монгол, Энэтхэг, Мексик, БНХАУ зэрэг улсын 15 их дээд сургууль, судалгааны байгууллага, технологийн компаниуд оролцож байна. Төслийн эхлэлийн уулзалт 2019 оны 1 дүгээр сарын 30-аас 2 дугаар сарын 1-ний өдрүүдэд Италийн Трэнтогийн их сургууль дээр болж манай сургуулиас Машин оюуны лабораторийн Мэдлэг ба өгөгдлийн инженерчлэлийн багийн ахлагч Др. Г.Амарсанаа, Хэл боловсруулалтын багийн ахлагч Др. Ч.Алтангэрэл нарын бүрэлдэхүүнтэй оролцоод иржээ.

Төслийн талаарх мэдээллийг @WeNetProject твиттер хаяг, <https://www.internetofus.eu> вэб сайтаар авч болох юм байна.

#ArtificialIntelligence #SocialInteractions #Ethics #WeNet

## ШИНЭ МЭДЭЭ

Сайхан наадаарай!

МУИС-д элсэх хүсэлт гаргагчдын анхааралд

МУИС-ийн Хангамж, үйлчилгээний газрын зарим ажилтнуудыг шагналаа

Оюуны өмчийг бизнесийн эргэлтэд оруулах боломж нэмэгдэж байна

МУИС-ийн номын сан ISO 9001 стандартын магадлан аудитыг үл тохиролгүй хамгаалж гэрчилгээг үргэлжлүүлэн эзэмшихээр боллоо

## ЗАРЛАЛ



МУИС-д элсэх хүсэлт гаргагчдын анхааралд

2020-07-10



ТЕНДЕРИЙН УРИЛГА | ОУХНУС-ийн урсгал засвар

2020-07-07



ТЕНДЕРИЙН УРИЛГА | Лабораторийн багаж, тоног төхөөрөмж суурилуулах, засвар үйлчилгээ

2020-07-07



ТЕНДЕРИЙН УРИЛГА | Биеийн тамирын заалны таазны дулаалгын ажил

2020-07-07



ТЕНДЕРИЙН УРИЛГА | БС-ийн сургалтын тоног төхөөрөмж

2020-07-07

— ДЭЛГЭРЭНГҮЙ —



## ХОЛБООСУУД

- ≡ АХИСАН ТҮВШНИЙ СУРГУУЛЬ
- ≡ ДОТООД ДҮРЭМ ЖУРАМ
- ≡ ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН МЭДЭЭЛЭЛ
- ≡ АЖЛЫН БАЙР
- ≡ ДОТУУР УТАСНЫ ЖАГСААЛТ
- ≡ ДИПЛОМ ШАЛГАХ
- ≡ ТЭТГЭЛЭГ
- ≡ МОНГОЛ ХЭЛНИЙ ВИКИТОЛЬ
- ≡ ХОЛБОО БАРИХ

## ХОЛБОО БАРИХ

📍 Их сургуулийн гудамж - 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар

☎ 75754400, 77307730-1163

✉ news@num.edu.mn

📘 <https://www.facebook.com/muis1942>

🐦 [https://twitter.com/num\\_edu](https://twitter.com/num_edu)

📺 <https://www.youtube.com/channel/ucfwHf5c7a>

